1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эрсдэлийг музейн үзмэртэй шууд харьцан судалж, эмзэг байдал, өртөмтгий байдлыг тодорхойлон эрсдэлийг бууруулах, авран хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах;
2. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавих, судалгаанд үндэслэн тайлан гаргах, мэдээллийн сан бүрдүүлж бодлого төлөвлөлтөд ашиглуулах;
3. Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	**Хариуцлага, оролцооны хэлбэр:** Туслах -**Т**, Хариуцан гүйцэтгэх -**Г** Хянах -**Х** Шийдвэрлэх -**Ш**
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд судалгаа хийж, эрсдэлийн хүчин зүйл, эмзэг байдал, өртөмтгий байдлыг тодорхойлох;	Эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээ хийж тайлан боловсруулсан байна.	Х, Г
	2. Хөдлөх дурсгалт зүйлийн физик, орчны, биологийн болон хүний хүчин зүйлээс үүсэх эрсдэлийг тодорхойлон дүн шинжилгээ хийх;	Эрсдэлийн ангилал, үнэлгээ хийж дүгнэлт гаргасан байна.	Г
	3. Судалгааны үр дүнд үндэслэн хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх хамгаалалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах;	Эрсдэлийг бууруулах болон хамгаалалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг тайлагнасан байна.	Г
	4. Эрсдэлд өртөх магадлалтай хөдлөх дурсгалт зүйлийг авран хамгаалах, хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах арга хэмжээний санал боловсруулах;	Хамгаалалтын арга хэмжээний санал боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулсан байна.	Г
	5. Хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын стандарт, шаардлагын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, мэргэжлийн зөвлөмж боловсруулах;	Стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийж мэргэжлийн зөвлөмж боловсруулсан байна.	Г
	6. Соёлын өвийг хамгаалах чиглэлээр оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;	Хамтын ажиллагааны үр дүн, хэрэгжилтийн талаар тайлан гаргасан байна.	Г
2. дугаар зорилтын хүрээнд	1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавих;	Хяналт шалгалт хийж тайлан, илэрсэн зөрчил, эрсдэлийн бүртгэл боловсруулсан байна.	Г
	2. Хяналт, судалгааны үр дүнд үндэслэн мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж боловсруулах;	Мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж боловсруулж хэрэгжилтийг тайлагнасан байна	Г
	3. Хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд мониторинг хийж, тайлан боловсруулах;	Мониторингийн үнэлгээ хийж тайлан боловсруулсан байна.	Г, Х
	4. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эрсдэлийн судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх, шинэчлэх;	Эрсдэлийн мэдээллийн санг бүрдүүлж шинэчилсэн,	Г

		бүртгэлд хамрагдсан дурсгалт зүйлийн тоо.	
	5. Судалгаа, хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж, бодлого төлөвлөлтөд ашиглуулах санал боловсруулах;	Судалгааны тайлан боловсруулж, бодлого төлөвлөлтөд ашиглах санал дэвшүүлсэн байна	Г
	6. Соёлын өвийн судалгааны чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бэлтгэж нийтлүүлэх, сургалт сурталчилгаанд оролцох;	Нийтлүүлсэн өгүүлэл, илтгэл, сургалт сурталчилгааны тоо.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Эрхэлсэн ажлын хүрээнд байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	2. Хариуцсан ажлын хүрээнд мөрдөж буй дүрэм, журам, арга зүйг боловсронгуй болгох санал боловсруулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	3. Дээд шатны байгууллага болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;	Үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байна.	Г
	4. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу ажлын хэсэг, зөвлөл, комиссын үйл ажиллагаанд оролцох;	Хүлээсэн үүргээ хугацаанд нь чанартай биелүүлсэн байна.	Г
	5. Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх;	Тухай бүр хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.	Г
	6. Эрхэлсэн ажлын хүрээнд бүрдүүлсэн баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу эмхлэн цэгцэлж архивд шилжүүлэх.	Архив, албан хэрэг хөтлөлтийн журамд нийцсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх;	
Мэргэжил	Түүх, археологи (0222), угсаатны зүй, соёл судлал (031401), соёлын өв судлал (031407), музей судлал (032203), гамшгийн эрсдэлийн менежмент, соёлын өвийн менежмент, палеонтологи,	
Мэргэшил	Соёл, соёлын өв, гамшиг, эрсдэлийн чиглэлээр сургалтад хамрагдсан байх;	
Туршлага	Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан байх;	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах, - дүн шинжилгээ хийх илтгэх ур чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;

	Асуудал шийдвэрлэх	- судалгаа хийх, үр дүнгээс хамааруулан газрын үйл ажиллагааг төлөвлөхөд оролцох; - асуудал шийдвэрлэх, өөрийн ажлын чиг хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулах - аливаа харилцааг хэрэгжүүлэх арга зам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний төсөлд санал өгөх;
	Багаар ажиллах	- мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - ажлын чиг хүрээнд хамтарч ажиллах;
	Бусад	- албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах; - гадаад хэлний мэдлэгтэй байх; - компьютерийн хэрэглээний программ болон мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - багаар ажиллах, багийн амжилтыг дэмжиж, бусдад таниулах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
- Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
	- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгууллагууд, - Соёлын өвийг өмчлөгч, эзэмшигч төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд, - Гамшиг эрсдэлийн судалгаа, хамтын ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, - ЮНЕСКО, ИКОМОС зэрэг олон улсын байгууллагууд, - ШУА-ийн хүрээлэнгүүд, Их дээд сургуулиуд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**
Албан тушаал: АВРАН ХАМГААЛАХ, ЭРСДЭЛИЙН СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА ..... Г.АНХСАНАА (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр	Байгууллагын нэр: СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ Шийдвэрийн огноо: 2026.03.16 Дугаар: А/13 (тамга/тэмдэг) ЗАХИРАЛ ..... Г.ЭНХБАТ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдөр

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ
9104203 ХНТ1839
11 8155932

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар тушаал
Дагаж мөрдөх огноо:	2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Соёлын өвийн үндэсний төв	Мэдээллийн технологийн газар
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Мэдээллийн технологийн газрын дарга	ТҮСБ-6
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
08.30-17.30	Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хороолол
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн соёлын биет ба биет бус өвийн бүртгэл, мэдээллийн программ хангамжийн ашиглалт, аюулгүй байдал, хадгалалт болон программ хангамжийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн хөгжлийг төлөвлөх, чиглүүлэх, нэгдсэн удирдлагаар зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, Үндэсний төвийн албан ажлын компьютерын болон харилцаа холбооны системийн засвар үйлчилгээ, ашиглалт, хөгжил төлөвлөлтийг удирдан зохион байгуулах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг Үндэсний төвийн захирлын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Байгууллагын удирдах үйл ажиллагаанд оролцож санал боловсруулах, сурталчлах;
2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангуудын үйл ажиллагаанд ашиглагдаж буй соёлын биет ба биет бус өвийн цахим бүртгэлийн программ хангамжийн аюулгүй байдал, хадгалалт, шинэчлэлт, хөгжүүлэлтийг төлөвлөх, зохион байгуулах, хянах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;
3. Нэгжийн албан хаагчдын үйл ажиллагааг удирдлага, манлайллаар хангах, дүгнэх, мэргэшүүлэх, мэдлэг чадавхыг сайжруулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	**Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг**	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	**Хариуцлага, оролцооны хэлбэр:** Туслах -**Т**, Хариуцан гүйцэтгэх -**Г** Хянах -**Х** Шийдвэрлэх -**Ш**
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагын бодлого болон төсөв хэлэлцэх, үйл ажиллагааг төлөвлөхөд оролцох;	Байгууллагын стратеги зорилт болон төсвийн төлөвлөгөөнд газрын саналыг тусгаж, хэрэгжилтийг хангасан байна.	Г
	2. Төрөөс хэрэгжүүлж буй “Цахим монгол” системд соёлын биет ба биет бусийн өвийн бүртгэлийн программ хангамжуудыг холбох, хөгжүүлэхэд хамтран оролцох, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Соёлын өвийн бүртгэл цахим системд холбох ажил хийгдсэн байна.	Г
	3. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн ERP нэгдсэн сүлжээг ашиглах, хөтлөх, зохион байгуулахад удирдлагаар хангах;	ERP систем дээрх албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа тогтмолжиж, ашиглалт сайжирсан байна.	Г
	4. Серверийн өрөөний ашиглалт, интернэтийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Сервер болон сүлжээний төхөөрөмжүүдийн ажиллагаа тогтвортой байж, сааталгүй ажиллах нөхцөл бүрдсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Чиг үүрэгтэй холбоотой төсөл, хөтөлбөр боловсруулах, үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээ төлөвлөх;	Боловсруулсан төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө нь бодлогын баримт бичигт нийцсэн, хэрэгжих нөөц, хугацааг оновчтой тодорхойлсон байна.	Г
	2. Соёлын өвийн цахим бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах;	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлагдаж, өгөгдөл алдагдах, устахаас хамгаалагдсан байна.	Г
	3. Хууль, хяналтын байгууллагуудыг соёлын өвийн мэдээ, мэдээллээр түргэн шуурхай хангах ажлыг зохион байгуулахад хамтран ажиллах;	Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв өгсөн байна.	Г
	4. Соёлын биет ба биет бус өвийн программ хангамжийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн	Программ хангамжийн хэтийн төлөвлөгөө боловсруулагдаж,	Г, Х

	хэтийн хөгжлийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;	шинэчлэлт, хөгжүүлэлтийн ажил хугацаандаа, технологийн шаардлагын дагуу хийгдсэн байна.	
	5. Компьютерын хэрэглээний болон системийн шаардлагыг хангахуйц технологийг тодорхойлох үүднээс удирдлага, хэрэглэгчид, техникийн ажилтнуудтай зөвлөлдөх;	Технологийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, системийн шинэчлэл, техник хангамжийн шийдэл нь мэргэжлийн түвшинд батлагдсан байна.	Г
	6. Соёлын өвийн бүртгэлийн системийн аюулгүй байдлыг хангах, системийн задлан шинжээч, программ зохиогч, компьютерын чиглэлийн бусад ажилтанд ажил хуваарилах, хянах, байгууллагын технологийн хэрэглээ болон хэрэгцээнд үнэлгээ хийх;	Системийн аюулгүй байдал хангагдаж, нэгжийн ажилтан бүр чиг үүргийн дагуу ажлаа чанартай гүйцэтгэсэн байна. Технологийн хэрэгцээг зөв тодорхойлсноор байгууллагын цахим шилжилт эрчимжсэн байна.	Г, Х
	7. Техник хангамж болон программ хангамжийг ашиглах, шинэчлэх талаар зөвлөмж гаргах, сургалт зохион байгуулах;	Технологийн шинэчлэлийн зөвлөмжүүд боловсруулагдаж, сургалт зохион байгуулагдаж ажилтнуудын техникийн мэдлэг, чадвар дээшилсэн байна.	Г
	8. Соёлын өвийг хадгалж хамгаалах, мэдээллийн технологи аюулгүй байдлын чиглэлээр олон нийттэй холбоо харилцаа тогтоож, уулзалт, хурал зөвлөгөөн, хандивын үйл ажиллагаанд оролцох;	Гадаад, дотоод хамтын ажиллагаа өргөжиж, мэдээллийн технологийн чиглэлээр дэмжлэг, хандив тусламж авах боломж бүрдсэн байна.	Г
	9. Мэдээлэл технологитой холбоотой асуудлаар хурал, зөвлөгөөн, семинарт байгууллагаа төлөөлөн оролцох;	Хурал, зөвлөгөөнд оролцож, техник технологийн шинэ мэдээллээр байгууллагыг хангасан байна.	Г
	10. Байгууллагын албан ёсны www.ncch.gov.mn цахим хуудсанд оруулах газар нэгжүүдийн үйл ажиллагааны нээлттэй мэдээллийг оруулах ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Цахим хуудасны мэдээлэл тогтмол шинэчлэгдэж, Шилэн дансны тухай хууль болон Мэдээллийн ил тод байдлын шаардлагыг бүрэн хангасан байна.	Г, Х

3 дугаар зорилтын хүрээнд	1. Нэгжийн үйл ажиллагааг удирдаж, албан хаагчдад чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, ажлын гүйцэтгэлийг дүгнэх, хяналт тавих;	Удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлийг дүгнэж, хяналт тавьж ажилласан байна.	Г
	2. Ажлын үнэлгээ, ажил мэргэжлийн ур чадварын мэдээллийг байнга шинээр бэлдэж танилцуулах, сургалтанд хамруулах;	Ур чадварын түвшинг тогтоож, сургалтын хэрэгцээг оновчтой тодорхойлж, мэргэшүүлэх арга хэмжээнд хамруулснаар ажлын бүтээмж нэмэгдсэн байна.	Г
	3. Цаг үеийн мэдээллийг тухай бүр хүргэж ажиллах;	Мэдээллээр хангасан байна.	Г
	4. Ажилтнуудыг мэргэшүүлэх, гадаад, дотоодод суралцах нөхцөл, боломжоор хангаж, дэмжих, сургалт зохион байгуулах;	Гадаад, дотоодын мэргэшүүлэх сургалт, хөтөлбөрт хамрагдсан ажилтнуудын тоо нэмэгдэж, олон улсын туршлага, техник технологийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримтлан ажиллах;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
	2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллах, хяналт тавих, дүрэм, журам боловсруулахад оролцох;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
	3. Эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох баримтыг “Байгууллагын хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивд шилжүүлэх;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
	4. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журмын хэм хэмжээг мөрдөх;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
	5. Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хамт олны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох.	Хамт олны үйл ажиллагаанд манлайлан оролцсон байна.	Г
5. **III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА**			
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;		

Мэргэжил	- Программ хангамж, түүний хэрэглээ хөгжүүлэлт-ба шинжилгээ (0613), түүх, археологи (0222), соёл судлал (021302), антропологи (031404).	
Мэргэшил	Мэдээллийн технологи, программ хангамж чиглэлээр мэргэшсэн байх;	
Туршлага	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- эрсдэлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох; - ажил үүргийг тэнцвэртэй хуваарилах; - албан хаагчидтай ижил тэгш харьцах; - бусад;
	Дүн шинжилгээ хийх	- мэдээлэлд тулгуурлан бүтэц, чиг үүргийн шинжилгээ хийх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаварын талаар бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах; - бусад;
	Асуудал шийдвэрлэх	- асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид оновчтой, шуурхай шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - аливаа харилцааг хэрэгжүүлэх арга зам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний төсөлд санал өгөх; - бусад;
	Манлайлах	- ёс зүйгээр хамт олноо үлгэрлэн манлайлах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхуйц ажил хэрэгч харилцаа бий болгох; - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш харьцах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - бусад;
	Бусад	- албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - гадаад хэлний мэдлэгтэй байх; - компьютерын хэрэглээний программ болон мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - багаар ажиллах, багийн амжилтыг дэмжиж, бусдад таниулах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - бусад;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Соёлын өвийн үндэсний төвийн захирал

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: - Программист - 1	Бусад харилцах субъект: - Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгууллагууд,

- Инженер (Газар зүйн мэдээллийн зайнаас тандан судлах) - 1 - Компьютер графикч - 1	- Дэлхийн өвийн хамгаалалтын захиргаад, - Улсын болон 21 аймаг, нийслэл орон нутгийн музей, сумдын ОНСТанхим, - Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, - Соёлын өвийг өмчлөгч, эзэмшигч төрийн ба төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**
Албан тушаал: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА …….О.БАТЧУЛУУН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр	Байгууллагын нэр: СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ Шийдвэрийн огноо: 2026.03.16 Дугаар: А/13 (тамга/тэмдэг) ЗАХИРАЛ……Г.ЭНХБАТ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны 03 дугаар сарын 16 -ны өдөр

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ
9104203 ХНТ1839
11181555930

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар тушаал
Дагаж мөрдөх огноо:	2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Соёлын өвийн үндэсний төв	Мэдээллийн технологийн газар
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Инженер (Газар зүйн зайнаас тандан судлах)	ТҮСБ-4
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
08.30-17.30	Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хороолол
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Хамаагүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын арга аргачлал ашиглан соёлын өвийг бүртгэх, зураглах, мэдээлэл боловсруулах ажлыг гүйцэтгэж гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Зайнаас тандан судлах арга, аргачлалаар мэдээллийн системд соёлын өвийг бүртгэх, зураглал бий болгох;
2. Мэдлэг чадвараа байнга хөгжүүлж, өндөр түвшний мэргэжилтэн болж чадавхжих.
3. Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	**Хариуцлага, оролцооны хэлбэр:** Туслах -**Т**, Хариуцан гүйцэтгэх -**Г** Хянах -**Х** Шийдвэрлэх -**Ш**
1 дугаар зорилтын хүрээнд	1. Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын арга аргачлал ашиглан өндөр нарийвчлал бүхий Монгол орны цахим газрын зураг дээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг бүртгэх, зураглах, мэдээлэл боловсруулах ажлыг гүйцэтгэх;	Монгол орны түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудын цахим мэдээллийн сангийн зураглал үнэн зөв, бодитой шинэчлэгдсэн байна.	Г
	2. Газар зүйн мэдээллийн систем болон зайнаас тандан судлалын өгөгдлийг 3D дүрслэлийн дэвшилтэт программ хангамжуудыг ашиглан чанарын өндөр түвшинд гүйцэтгэх;	3D загварчлал, дижитал өгөгдөл нь нарийвчлалын стандартыг хангаж, судалгаа болон сурталчилгааны ажилд ашиглахад бэлэн болсон байна.	Г
	3. Орон зайн мэдээллийг бусад газруудтай уялдуулж, шаардлагатай орон зайн мэдээллээр хангаж ажиллах;	Стандарт шаардлага хангасан орон зайн өгөгдлөөр хангагдаж, мэдээллийн давхцал болон зөрүү арилсан байна.	Г
	4. Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын чиглэлээр сэдэвчилсэн судалгаа хийх;	Соёлын өвийн байршил, төлөв байдал, хүрээлэн буй орчны өөрчлөлтийг зайнаас тандан судлалын өгөгдлөөр нотолсон судалгааны тайлан гарсан байна.	Г
	5. Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын боловсруулалт ашиглан соёлын өвийн орон зайн дүн шинжилгээ хийх;	Соёлын өвийн байршлын хамаарал, нягтрал, хүрээлэн буй орчны нөлөөлөл,тоон өгөгдлөөр эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.	Г
	6. Байгууллагын албан ёсны www.ncch.gov.mn сайтад оруулах нэгжийн үйл ажиллагааны нээлттэй мэдээллийг бэлтгэж өгөх;	Мэдээллийг бэлтгэж, байршуулсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Салбарын хөгжилд гарч буй дэвшил, шинэ мэдээ, мэдээллээс хоцрохгүй байх;	Ажлын бүтээмж, үр дүн сайжирсан байна.	Г
	2. Мэргэжлийн ур чадвар, мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэлийг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх;	Зайнаас тандан судлал (ЗТС) болон ГЗМС-ийн технологийн шинэ шийдэл, хиймэл дагуулын өгөгдөл	Г

		боловсруулах дэвшилтэт аргуудыг судалж, соёлын өвийг баримтжуулахад нэвтрүүлсэн байна.	
	3. Судалгаа шинжилгээ хийх, эрдмийн зэрэг цолоо ахиулах, мэргэших, дадлагажих мэргэжлийн сургалтад идэвхтэй оролцох;	Мэргэжлийн зэрэг, түвшний сургалтад хамрагдсан байна.	Г
	4. Гадаад хэлний зэрэг бусад чадварыг сайжруулахад бие даан болон сургалтад хамрагдах зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг нэвтрүүлэх;	Мэргэжлийн техникийн баримт бичиг, гадаад эх сурвалжийг бие даан ашиглах чадвар дээшилсэн байна.	Г
	5. Байгууллагын дохиолол хамгааллын системийн хэвийн үйл ажиллагааг хангахад камер, хяналтын дэлгэц, хөдөлгөөн мэдрэгч зэрэг тоног төхөөрөмж, техникийн бэлэн байдал ажиллагааг байнга шалгаж, хянах тавих;	Байгууллагын аюулгүй байдлын системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, техникийн саатал болон эвдрэлийг зассан байна.	Г, Х
	6. Ажилтнуудын цаг бүртгэлийн нүүр танилтын системийн өгөгдлийн санг хариуцах, шинэ ажилтны бүртгэл хийх, системийн алдааг засварлах;	Ажилтны цаг бүртгэлийн мэдээлэл болон техникийн алдаа саатал тухай бүр шийдвэрлэгдсэн байна.	Г
	7. Байгууллагын орчинд цаг үеийн шинжтэй хурал, урлаг, соёлын үйл ажиллагааны хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тоног, төхөөрөмжийг ажиллуулах;	Техникийн бэлэн байдал бүрэн хангагдсан байна.	Г
	8. Камерын байршлын тэмдэглэлийг хөтөлж холбогдох газар нэгжүүдэд хүргүүлэх;	Камеруудын байршил, хамрах хүрээний зураглал, бүртгэлийг хөтөлж, мэдээллээр хангасан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Эрхэлсэн ажлын хүрээнд байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	2. Хариуцсан ажлын хүрээнд мөрдөж буй дүрэм, журам, арга зүйг боловсронгуй болгох санал боловсруулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	3. Дээд шатны байгууллага болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;	Үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байна.	Г

	4. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу ажлын хэсэг, зөвлөл, комиссын үйл ажиллагаанд оролцох;	Хүлээсэн үүргээ хугацаанд нь чанартай биелүүлсэн байна.	Г
	5. Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх;	Тухай бүр хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.	Г
	6. Эрхэлсэн ажлын хүрээнд бүрдүүлсэн баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу эмхлэн цэгцэлж архивд шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн журамд нийцсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр, түүнээс дээш зэрэгтэй байх;	
Мэргэжил	- Газар зүйн мэдээллийн систем (053202), газрын кадастр (073103),	
Мэргэшил	-	
Туршлага	-	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;
	Асуудал шийдвэрлэх	- судалгаа хийх, үр дүнгээс хамааруулан үйл ажиллагааг төлөвлөх, өөрийн ажлын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулах;
	Багаар ажиллах	- мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - ажлын чиг үүргийн хүрээнд хамтарч ажиллах;
	Бусад	- албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах, - албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх, - бүтээлч, санаачлагатай ажиллах, - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, - кирилл болон үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах чадвартай байх, - гадаад хэлний мэдлэгтэй байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
- Мэдээллийн технологийн газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгууллагууд, - Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, - Соёлын өвийг өмчлөгч, эзэмшигч төрийн ба төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**
Албан тушаал: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА ..... О.БАТЧУЛУУН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр	Байгууллагын нэр: СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ Шийдвэрийн огноо: 2026.03.16 Дугаар: А/13 (тамга/төмдэг) ЗАХИРАЛ ..... Г.ЭНХБАТ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны 03 дугаар сарын 16 -ны өдөр

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ
9104203 ХНТ1839
8155933

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар тушаал
Дагаж мөрдөх огноо:	2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Соёлын өвийн үндэсний төв	Мэдээллийн технологийн газар
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Программист	ТҮСБ-5
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
08.30-17.30	Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хороолол
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Шат, шатны бүртгэл, мэдээллийн сангийн соёлын биет болон биет бус өвийн цахим бүртгэлийн программын найдвартай ажиллагаа болон мэдээллийн нэгдсэн цахим санг хариуцах, байгууллагын үйл ажиллагааны интернет сүлжээ, дохиолол хяналтыг сүлжээнд холбох, компьютер, программ хангамж, цахим сүлжээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, цахим сангийн техникийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангах, бүртгэл, мэдээллийн сангуудын дундын өгөгдлийн санг байгуулж төрийн болон холбогдох бусад байгууллагыг нэгдсэн сүлжээнд хамруулах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Соёлын биет болон биет бус өвийн бүртгэл хадгалагдаж буй программ хангамжуудын ашиглалт, хөгжүүлэлт, шинэчлэлтийг төлөвлөх, зохион байгуулах, заавар зөвлөмж, гарын авлага боловсруулах, хэрэгжилтийг хянах;
2. Мэдлэг чадвараа байнга хөгжүүлж, өндөр түвшний мэргэжилтэн болж чадавхжих;
3. Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.

Зорилт	**Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг**	**Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**	**Хариуцлага, оролцооны хэлбэр:** Туслах -**Т**, Хариуцан гүйцэтгэх -**Г** Хянах -**Х** Шийдвэрлэх -**Ш**
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Төрөөс хэрэгжүүлж буй “Цахим монгол” системд соёлын биет ба биет бусийн өвийн бүртгэлийн программ хангамжуудыг холбох, хөгжүүлэхэд хамтран оролцох, зохион байгуулах;	Соёлын өвийн мэдээлэл "E-Mongolia" системд бүрэн нэгдэж, иргэдэд хүрэх үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.	Г
	2. “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”, программ хангамж нэвтрүүлэхэд шийдлийг боловсруулах, нэмэлт өөрчлөлт хийх, хөгжүүлэх болон сонголт хийх, санал дүгнэлт гаргах, программ хангамжтай холбоотой төслүүдийг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Системийн шийдэл, нэмэлт өөрчлөлтүүд нь техникийн даалгаврын дагуу чанартай хийгдэж, программ хангамжийн төслүүд тогтоосон хугацаанд үр дүнтэй хэрэгжсэн байна.	Г
	3. Соёлын өвийн цахим бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх;	Өгөгдлийн сангийн нөөцлөлт тогтмол хийгдэж, мэдээлэл устгах, алдагдах эрсдэлээс хамгаалагдсан, системийн тасралтгүй ажиллагаа хангагдсан байна.	Г
	4. Хууль, хяналтын байгууллагуудыг соёлын өвийн мэдээ, мэдээллээр түргэн шуурхай хангах ажлыг зохион байгуулахад хамтран ажиллах;	Хүсэлтийн дагуу шаардлагатай өгөгдөл, мэдээллийг системээс үнэн зөв шүүж, шуурхай гаргаж өгсөн байна.	Г
	5. Соёлын биет ба биет бус өвийн программ хангамжийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн хэтийн хөгжлийг төлөвлөх, боловсруулах;	Программ хангамжийн хөгжүүлэлт, шинэчлэлнь соёлын өвийн бүртгэлийн хэрэгцээг бүрэн хангасан байна.	Г
	6. Программд туршилтын мэдээллүүдийг оруулан ажиллуулж, шаардлагатай тохиолдолд өөрчлөх ба программын ажиллагааны явцад гарч буй мэдээлэл, зааварчилгааг зөв эсэхийг хянах;	Программ хангамжийн алдаа (bug) болон зөрчил бүрэн илэрч засагдаж, хэрэглэгчдэд зориулсан зааварчилгаа болон системийн мессежүүд алдаагүй, ойлгомжтой байна.	Г

	7. Программ боловсруулах, кодолсон зааврыг тайлбарлах зэрэг программыг хэрэглэгчдэд шаардлагатай баримт бичгүүдийг бэлтгэх;	Хэрэглэгчийн гарын авлага бэлтгэгдсэнээр системийн ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг бууруулсан байна.	Г
	8. Үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, шинэ шаардлага нөхцөлд тохируулах, программын үйлдлийг өргөжүүлэх зорилгоор шинэчилж, засварлаж өргөжүүлэх ажлыг гардан гүйцэтгэх буюу удирдан хийлгэх;	Программ хангамжийн шинэчлэлт, өргөтгөлүүд нь хэрэглэгчийн шаардлагыг бүрэн хангаж, системийн ажиллагаа илүү уян хатан, үр ашигтай болсон байна.	Г
	9. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн ERP нэгдсэн сүлжээг ашиглах, хөтлөх, зохион байгуулахад бусад газар нэгжүүдтэй хамтрах;	ERP системийн ашиглалт тогтмолжиж, мэдээлэл солилцоо шуурхай болж, албан хэрэг хөтлөлтийн цахим шилжилт бүрэн хангагдсан байна.	Г
	10. Байгууллагийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, технологийн шийдэл боловсруулах, нэвтрүүлэх, интернетийн холболт, хяналтын камер, дотуур утасны хуваарилалт, тэдгээрийн холболтыг хийж, сүлжээний аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах;	Байгууллагын дотоод сүлжээ, интернет, холбоо дохиоллын системүүд тасралтгүй, найдвартай ажиллаж, мэдээллийн аюулгүй байдлын зөрчилгүй, техникийн бэлэн байдал бүрэн хангагдсан байна.	Г
	11. Хэрэглэгчдэд зориулсан мэдээллийн систем, программыг хэрэглэх гарын авлага бэлтгэх;	Хэрэглэгчийн гарын авлага нь ойлгомжтой, зураг болон тайлбар бүхий хэлбэрээр бэлтгэгдэж, систем ашиглагчдын техникийн мэдлэг дээшилж, алдаатай үйлдэл буурсан байна.	Г
	12. Байгууллагын албан ёсны ncch.gov.mn цахим хуудсанд оруулах газар нэгжүүдийн нэгтгэсэн мэдээллийг цахим хуудсанд байршуулах;	Цахим мэдээлэл тогтмол шинэчлэгдэж, иргэд, хэрэглэгчдийг байгууллагын үйл ажиллагааны үнэн зөв, мэдээллээр хангасан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Салбарын хөгжилд гарч буй дэвшил, шинэ мэдээ, мэдээллээс хоцрохгүй байх;	Мэдээллийн технологийн салбарын шинэ тренд, программ хангамжийн дэвшлийг байгууллагын үйл ажиллагаанд тохирох шийдлийг нэвтрүүлсэн байна.	Г

	2. Мэргэжлийн ур чадвар, мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэлийг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх;	Хувь хүний хөгжлийн болон мэргэшүүлэх төлөвлөгөөг биелүүлж, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ тогтмол өссөн байна.	Г
	3. Судалгаа шинжилгээ хийх, эрдмийн зэрэг цолоо ахиулах, мэргэших, дадлагажих мэргэжлийн сургалтад идэвхтэй оролцох;	Мэргэжлийн онол, практикийн мэдлэг дээшилж, судалгааны үр дүнг программ хангамжийн хөгжүүлэлтэд нэвтрүүлсэн байна.	Г
	4. Гадаад хэлний зэрэг бусад чадварыг сайжруулах сургалтад хамрагдах;	Мэргэжлийн техникийн баримт бичиг, гадаад эх сурвалжийг программ хангамжийн хөгжүүлэлтэд бие даан ашиглах чадвар дээшилсэн байна.	Г
	5. Байгууллагын орчинд цаг, үеийн шинжтэй хурал, урлаг, соёлын үйл ажиллагааны хэвийн үйл ажиллагаанд хангахад шаардлагатай тоног, төхөөрөмжийг ажиллуулах;	Хурал, арга хэмжээний үеэр техник хэрэгсэл (дуу авиа, дүрс бичлэг, сүлжээ)-ийн найдвартай ажиллагаа хангагдаж, техникийн сааталгүй явагдсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Эрхэлсэн ажлын хүрээнд байгууллага болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	2. Хариуцсан ажлын хүрээнд мөрдөж буй дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар саналаа боловсруулж, удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	3. Дээд шатны байгууллага болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;	Үүрэг даалгаварыг хэрэгжүүлсэн байна.	Г
	4. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу ажлын хэсэг, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд ажиллах;	Хүлээсэн үүргээ хугацаанд нь чанартай биелүүлсэн байна.	Г
	5. Эрхэлсэн ажлын хүрээнд баримт бичгийг холбогдох журмын дагуу эмхлэн цэгцэлж байгууллагын архивд шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн журамд нийцсэн байна.	Г
	6. Иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хугацаанд нь хариу өгөх;	Хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Бакалавр, түүнээс дээш зэрэгтэй байх;	
Мэргэжил	- Программ хангамж, түүний хэрэглээ хөгжүүлэлт-ба шинжилгээ (0613),	
Мэргэшил	Мэдээллийн технологиор мэргэшсэн бол давуу тал болно.	
Туршлага	-	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;
	Асуудал шийдвэрлэх	- судалгаа хийх, үр дүнгээс хамааруулан үйл ажиллагааг төлөвлөх, өөрийн ажлын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулах;
	Багаар ажиллах	- мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - ажлын чиг үүргийн хүрээнд хамтарч ажиллах;
	Бусад	- албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах, - албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх, - бүтээлч, санаачлагатай ажиллах, - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, - кирилл болон үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах чадвартай байх, - гадаад хэлний мэдлэгтэй байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: - Мэдээллийн технологийн газрын дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: - Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгууллагууд, - Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, - Соёлын өвийг өмчлөгч, эзэмшигч төрийн ба төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Албан тушаал: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА .....О.БАТЧУЛУУН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр	Байгууллагын нэр: СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ Шийдвэрийн огноо: 2026.03.16 Дугаар: 1A/13 (тамга/тэмдэг) ЗАХИРАЛ .....Г.ЭНХБАТ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны 03 дугаар сарын 16 -ны өдөр

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ
9104203 ХНТ1839
11/8155933

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар тушаал
Дагаж мөрдөх огноо:	2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Соёлын өвийн үндэсний төв	Мэдээллийн технологийн газар
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Компьютер графикч	ТҮСБ-4
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
08.30-17.30	Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хороолол
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Дуу, дүрс бичлэг, график, хөдөлгөөний дүрсийг ашиглан соёлын өвийг олон нийтэд сурталчлан таниулах цахим видео танилцуулга, баримтат нэвтрүүлэг, гурван хэмжээст бүтээгдэхүүн хийх ба боловсруулах, зураг, аудио, видео болон дуу, дүрсний бичлэг эвлүүлгийн төхөөрөмж дээр ажиллах зэрэг ажлыг хийж гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Соёлын өвийг олон нийтэд таниулах, сурталчлахад цахим видео танилцуулга, баримтат нэвтрүүлэг, контентын компьютерын график дизайныг бэлтгэх, хийх, боловсруулах, сошиал платформд байршуулах зэрэг ажлыг гүйцэтгэх;
2. Мэдлэг чадвараа байнга хөгжүүлж, өндөр түвшний мэргэжилтэн болж чадавхжих;
3. Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	**Хариуцлага, оролцооны хэлбэр** Туслах -**Т**, Хариуцан гүйцэтгэх -**Г** Хянах -**Х** Шийдвэрлэх -**Ш**
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Мультимедиа программ, арга хэрэгсэл, компьютер график, программын хэл зэргийг ашиглан соёлын өвийн мэдээлэл, сурталчилгааны дижитал хөдөлгөөнт дүрс, презентаци, аудио болон видео бичлэг зэргийн график дизайн зохиох, боловсруулах;	Соёлын өвийн онцлог, агуулгыг орчин үеийн график дизайны шийдлээр бэлтгэж, сурталчилгааны үйл ажиллагаанд ашиглагдсан байна.	Г
	2. Интернетийн стратеги, вэб хуудсанд суурилсан аргачлал, төлөвлөгөө боловсруулах, дүн шинжилгээ хийх зэрэгт туслалцаа үзүүлэх;	Байгууллагын цахим дахь вэб хуудасны хандалтын тоо болон хэрэглэгчдийн идэвх тогтмол өссөн байна.	Г
	3. Байгууллагын орчинд цаг үеийн шинжтэй танхим болон цахимаар зохион байгуулагдах, хурал, урлаг, соёлын арга хэмжээний техник, тоног төхөөрөмжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллуулах;	Танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулагдсан арга хэмжээний үеэр тоног төхөөрөмжүүд сааталгүй ажиллаж, техникийн бэлэн байдал бүрэн хангагдсан байна.	Г
	4. Зохиомж, зохиолын санаа, зураг гэх мэт ажлын ерөнхий санааг ашиглан ажлын төлөвлөгөөг боловсруулах, аудио, видео хальс, холбогдох материалуудыг бүртгэх, аюулгүй орчинд хадгалах;	Мэдээллийн аюулгүй байдал хангагдсан орчинд хадгалагдсан байна.	Г
	5. Дуу бичигч, монтажлагч тоног төхөөрөмж ашиглан видео, баримтат нэвтрүүлэг, контент хийхэд хар дүрсийг монтажлах;	Дуу болон дүрсний техникийн алдаагүйгээр анхны монтажийг (rough cut) гүйцэтгэсэн байна.	Г
	6. Тухайн жилд хийгдсэн соёлын өвийн цахим сурталчилгааны файл, холбогдох материалыг архивын дүрэм, журмын дагуу товьёгжуулж, СӨУНБМСангийн хариуцсан ажилтанд хүлээлгэн өгөх;	Архивын стандартын дагуу товьёгжуулж, СӨУНБМСанд бүрэн хүлээлгэн өгөгдсөн байна.	Г
	7. Соёлын биет өвийг гурван хэмжээстээр сканердах болон фотограмметрийн аргаар загварчлаж, дата мэдээллийг бэлтгэхж, соёлын өвийн дижитал,	Дижитал архивын сангийн хадгалалт, хамгаалалтын хяналт сайжирсан байна.	Г

	хадгалалт хамгаалалтыг сайжруулах;		
	8. Мультимедиа программ хангамж ашиглалтын хүрээнд шаардлагатай дата өгөгдлийг боловсруулах, контент бүтээх явцыг хурдасгахад хиймэл оюуны дэвшилтэт технологийн хэрэгслүүдийг ашиглах.	Хиймэл оюуны (AI) технологиудыг ашиглаж бүтээлийн чанар, хүртээмж дээшилсэн байна.	Г
	9. Байгууллагын албан ёсны цахим платформууд болох вэб сайт, “YouTube” суваг, “Facebook” хуудас зэрэгт нийтлэх шаардлагатай мэдээллүүдийн датаг график, мультимедиа технологи ашиглан дахин боловсруулах;	Цахим платформуудад нийтлэгдэх мэдээллийн соёлын өвийн сурталчилгааны хүртээмж дээшилсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Салбарын хөгжилд гарч буй дэвшил, шинэ мэдээ, мэдээллээс хоцрохгүй байх;	Дизайн, мультимедиа болон хиймэл оюуны технологийн сүүлийн үеийн чиг хандлага, арга аргачлалыг судалж, бүтээлчээр нэвтрүүлсэн байна.	Г
	2. Мэргэжлийн ур чадвар, мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэлийг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх;	Гүйцэтгэж буй ажлын чанар, хурд болон бүтээмж тогтмол өссөн байна.	Г
	3. Боловсролын зэргээ ахиулах, мэргэших, дадлагажих мэргэжлийн сургалтад идэвхтэй оролцох;	Мэргэжлийн зэрэг, түвшний сургалтад хамрагдсан байна.	Г
	4. Гадаад хэлний зэрэг бусад чадварыг сайжруулахад бие даан болон сургалтад хамрагдах зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг нэвтрүүлэх;	Мэргэжлийн техникийн баримт бичиг, гадаад эх сурвалжийг бие даан ашиглах чадвар дээшилсэн байна.	Г
	5. Байгууллагын дохиолол хамгааллын системийн хэвийн үйл ажиллагааг хангахад камер, хяналтын дэлгэц, хөдөлгөөн мэдрэгч зэрэг тоног төхөөрөмж, техникийн бэлэн байдал ажиллагааг байнга шалгаж, хянах тавих;	Байгууллагын аюулгүй байдлын системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, техникийн саатал болон эвдрэлийг зассан байна.	Г, Х
	6. Камерын байршлын тэмдэглэлийг хөтөлж холбогдох газар нэгжүүдэд хүргүүлэх;	Камеруудын байршил, хамрах хүрээний зураглал, бүртгэлийг хөтөлж, мэдээллээр хангасан байна.	Г

	1. Эрхэлсэн ажлын хүрээнд байгууллага болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	2. Хариуцсан ажлын хүрээнд мөрдөж буй дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар саналаа боловсруулж, удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	3. Дээд шатны байгууллага болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;	Үүрэг даалгаварыг хэрэгжүүлсэн байна.	Г
	4. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу ажлын хэсэг, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд ажиллах;	Хүлээсэн үүргээ хугацаанд нь чанартай биелүүлсэн байна.	Г
	5. Эрхэлсэн ажлын хүрээнд баримт бичгийг холбогдох журмын дагуу эмхлэн цэгцэлж байгууллагын архивд шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн журамд нийцсэн байна.	Г
	6. Иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хугацаанд нь хариу өгөх;	Хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр түүнээс дээш зэрэгтэй байх;	
Мэргэжил	Дуу, дүрсийн техник болон медиа үйлдвэрлэл (0211).	
Мэргэшил	-	
Туршлага	-	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;
	Асуудал шийдвэрлэх	- судалгаа хийх, үр дүнгээс хамааруулан үйл ажиллагааг төлөвлөх, өөрийн ажлын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулах;
	Багаар ажиллах	- мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - ажлын чиг зргийн хүрээнд хамтарч ажиллах;
	Бусад	- албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах, - албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх, - бүтээлч, санаачлагатай ажиллах, - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, - кирилл болон үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах чадвартай байх, - гадаад хэлний мэдлэгтэй байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: - Мэдээллийн технологийн газрын дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: - Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгууллагууд, - Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, - Соёлын өвийг өмчлөгч, эзэмшигч төрийн ба төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**
Албан тушаал: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА .....О.Бат..... О.БАТЧУЛУУН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр	Байгууллагын нэр: СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ Шийдвэрийн огноо: 2026.03.16 Дугаар: А/13 (тамга/тэмдэг) ЗАХИРАЛ.....Г.ЭНХБАТ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны 03 дугаар сарын 16 -ны өдөр